



АР ТАЛЫН АЛБАНЫ ШИЛДЭГ ОФИЦЕРУУД ТОДОРЛОО

Мэргэжлийн цэрэгт суурилсан Зэвсэгт хүчний Ар талын офицерын бэлтгэлийг дээшлүүлэх, ар талын хангалтыг зохион байгуулж явуулах дадлага, ур чадварыг нэмэгдүүлэх, албаны даргад тавигдаж буй шалгуур үзүүлэлтийг хангахад дэмжлэг болох зорилгоор ЗХЖШ-ын даргын тушаалын дагуу "Ар талын шилдэг офицер-2022" цогцолбор тэмцээнийг энэ сарын 13-14-ний өдрүүдэд Хужирбулан дахь Сургалтын нэгдсэн төвд зохион байгууллаа.

Тус тэмцээнийг гарааны өмнөх ажиллагаа, маршийн замд гүйцэтгэх ажиллагаа гэсэн хоёр үе шаттайгаар явуулсан бөгөөд оролцогчид шатахууны, хүнс хувцасны, эрүүл мэндийн, орон сууцны, галын бэлтгэлийн, химийн, холбооны, байр зүйн, жолоодлогын гэсэн цэгүүдэд ур чадварын даалгавар биелүүлж үнэлгээ өгөх зарчмаар дүгнэсэн юм.

Тэмцээнд Зэвсэгт хүчний 17 нэгтгэл, анги, байгууллагын алба хаагчид оролцсоноос Зэвсэгт хүчний 310 дугаар ангийн тамирчин ахмад С.Алтангэрэл тэргүүн байр, 311 дүгээр ангийн тамирчин ахмад М.Тулга дэд байр, 011 дүгээр ангийн тамирчин ахмад Т.Баасанхүү гутгаар байрт тус тус шалгарав.

Ташрамд дурдахад энэ удаагийн тэмцээнд анх удаа эмэгтэй цэргийн алба хаагч оролцож (Зэвсэгт хүчний 339 дүгээр ангийн ар талын офицер дэслэгч Х.Цэцэгбал) "Ар талын дарга нарын холбоо"-ноос тусгай шагнал хүртсэн онцлог үйл явдалтай байлаа.



ЗЭВСЭГТ ХҮЧИН АВАРГА ТОГООЧОО ШАЛГАРУУЛАВ



түвшинд болсныг онцолж байв.

Чадварлаг тогооч шалгаруулах ганцаарчилсан төрөлд Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн тогооч Болортуул шалгарсан бол багийн нийлбэр дүнгээр нэгдүгээр байрт Зэвсэгт хүчний 256 дугаар анги, хоёрдугаар байрт Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэл, гуравдугаар байрт Зэвсэгт хүчний 330 дугаар

байрт шалгарч аваргын цомоо хадгалж чадсан юм.

Ходоод хоосон үед ямар ч тулалдаанд ялалт байгуулна гэж үгүй. Тиймээс цэргийн хоол хамгийн уураглаг, шим тэжээлтэй байх ёстой. Зэвсэгт хүчний хээрийн хуурай хүнсийг "Хүн Од" ХХК захиалгаар нийлүүлдэг бөгөөд аварга тогооч шалгаруулах



анги, тусгай байрт Зэвсэгт хүчний 120, 311 дүгээр ангиуд тус тус шалгарч, авьяас чадвараараа манлайллаа. Ийнхүү дэд хурандаа Э.Цэнгэл ахлагчтай Зэвсэгт хүчний 256 дугаар анги хоёр дахь жилдээ тэргүүн

тэмцээнд оролцсон нийт бие бүрэлдэхүүнд бүтээгдэхүүний дээжээс гарын бэлэг болгон өгсөн юм.

Х.УНДАРМАА

ЗХЖШ-ын Материал, техникийн газраас "Аварга тогооч-2022" тэмцээнийг ес дэх жилдээ зохион байгууллаа. Энэ жилийн хувьд гадаа талбайд, ил гал дээр хээрийн нөхцөлд нэг, хоёрдугаар хоол, талх нарийн боов зэрэг бүх төрлийн хоол зууш, халуун уух зүйлс зэргээр нийт найман ангийн шилдэг тогооч нар өрсөлдөж, аваргаа додруулав.

Тэмцээн хоёр өдрийн турш дадлага ажил, онол гэсэн үе шаттайгаар явагдсан бөгөөд мэргэн буудагч

тогооч, авьяаслаг тогооч зэрэг нөхөрсөг тэмцээнийг хөтөлбөрийн төгсгөлд зохион байгуулж хамт олонч, эерэг уур амьсгалыг бий болгосон юм. Монголын тогооч нарын холбооны "Залуу мастер" сургалтын төвийн болон Үйлдвэрлэл урлалын политехник коллежийн хоол үйлдвэрлэлийн багш нар шүүгчийн бүрэлдэхүүнд ажилласан бөгөөд жилээс жилд нэгтгэл, ангийн тогооч нарын ур чадвар чанаржин сайжирч, тэмцээний ерөнхий зохион байгуулалт өндөр

Цахим шууданд

ЦЭРГИЙН ЖИНХЭНЭ АЛБА ХААЖ, ХАЛАГДАЖ ИРСЭН ДАЙЧДАА УГТАН АВЛАА

Төв сайхан нутгаасаа цэргийн албанд мордож, эх орноо батлан хамгаалах иргэний журамт үүргээ биелүүлж, албаа нэр төртэй хаан цэргийн албанаас бэлтгэлээр халагдаж байгаа дайчдаа угтан авлаа.



Энэхүү үйл ажиллагаанд аймгийн ЗДТГ-ын дарга бөгөөд Цэрэг татлагын товчооны дарга М.Отгонбат, Цэрэг татлагын товчооны орлогч дарга бөгөөд Цэргийн штабын дарга дэд хурандаа Т.Төмөрчөдөр, сумдын ЗДТГ-ын дарга нар болон ар гэрийн төлөөлөл оролцлоо. Тэд энэ цагийн зорилгыг биелүүлэн энх цагийн бүтээн байгуулалтад гар бие оролцон, орон нутгийнхаа нэр хүндийг өндөрт өргөж, батлан хамгаалах бодлогыг хэрэгжүүлэн өргөсөн тангарагтаа үнэнчээр зүтгээд ижий, аавдаа ийнхүү ирж байгаа юм. Энэ үеэр аймгийн ЗДТГ-ын дарга бөгөөд Цэрэг татлагын товчооны дарга

М.Отгонбат хэлсэн үгэндээ "Төв аймаг түүхийн аль ч үед эх орныхоо хөгжил, цэцэглэлт, энх цагийн бүтээн байгуулалтад хувь нэмрээ оруулсаар ирсэн. Цэргийн албанаас төрөлх аймгийнхаа нэрийг өндөрт өргөсөн БНМАУ-ын баатар, генерал, төр, нийгмийн нэрт зүтгэлтэн олноор төрөн гарсан байдаг. Үүний нэгэн адил та бүхний дотор салбар бүрийн алдартан гавьяатан

зогсож байгаа гэдэгт итгэл дүүрэн байна. Амьдралын их сургуульд суралцаад ирсэн та бүхэнд аймаг орон нутагт үйл ажиллагаа явуулдаг төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагууд ажиллах санал хүсэлт тавьж, орон нутагтаа ажиллах боломж олгож байгааг хүлээн авна гэдэгт итгэлтэй байна" хэмээсэн юм.

Ахмад С.СОЛОНГО

НАРАН МАНДАХ НУТГИЙНХАН ДАЙЧДАА ХҮНДЭТГЭН ЁСЛОЛ ТӨГӨЛДӨР ҮДЛЭЭ



Зэвсэгт хүчний 338 дугаар анги

Тус ангийн хугацаат цэргийн албанаас бэлтгэлээр халагдаж буй дайчид Байлдааны туганд хүндэтгэл үзүүлэхэд ангийн захирагч хурандаа П.Мөнхбат "Орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэж хөгжсөний 100, 101 жил, Сүхбаатар аймгийн түүхт 80 жил, Барилгын цэрэг үүсэн байгуулагдсаны 86 жилийн ой давхацсан энэ сайхан түүхэн

үйл явдлын гэрч болж, албаа нэр төртэй хаасан та бүхнээрээ эх орон, ээж аав тань бахархаж байгаа гэдэгт итгэл дүүрэн байна. Зэвсэгт хүчинд өөрсдийн эзэмшсэн мэргэжлээрээ ажиллах боломж та бүхний өмнө хэзээд нээлттэй байх болно" хэмээн халагдах дайчдадаа чин сэтгэлийн үгээ хэллээ. Энэ үеэр халагдаж буй дайчдад дурсгалын зүйл, талархлын захидал, гэрэл зургийг нь бэлэг болгон хадгалуулж, сурлага, хөдөлмөр, сахилга бат, спортоор бусдыгаа манлайлж, албаа үлгэр жишээ хаасан дайчдыг "Онц сурлагатан", "Онц буудагч", "Тамирчин дайчин" тэмдгээр шагнасан юм.

М ө н

ангийн хамт олон халагдаж буй дайчдаа жанжин Д.Сүхбаатарын өлгий нутаг Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын нутагт байрлах Монгол Улсын төр, цэргийн зүтгэлтэн хурандаа генерал Ж.Ёндон агсны нэрэмжит "Соёмбо" цогцолбор, Сүхбаатар аймгийн төв талбай, "Бурхантай хөшөө" цэцэрлэгт хүрээлэн, аймгийн Угсаатны зүйн музей болон бусад хөшөө, түүхэн дурсгалт газруудаар аялуулж, аймаг орон нутгийг танилцуулах, сурталчлах ажлыг зохион байгуулсны зэрэгцээ Политехникийн коллежтой хамтран "Халагдах цэргийн үдэшлэг" цэнгүүнийг зохион байгуулж, дуу бүжиг, урлагийн тоглолт, хөгжөөнт тэмцээн бүхий халуун дулаан уур амьсгал бүрдүүлсэн нэгэн үдшийг дурсамж дүүрэн өнгөрүүлсэн юм.



ХУГАЦААТ ЦЭРГИЙН АЛБАНААС АХЛАГЧИЙН АЛБАНД...

Сүхбаатар аймгийн Политехникийн коллежтой хамтран тус ангийн хугацаат цэргийн 40 алба хаагчийг сонгон, алба хаах хугацаанд нь барилгын засал чимэглэлчин, барилгын өрөгч угсрагч мэргэжлээр суралцуулан төгсгөж, мэргэжлийн үнэмлэх олголоо.

Барилгын өргөн мэргэжлээр сурч төгссөн эдгээр дайчдаас зургаан цэргийн алба хаагч өөрийн хүсэлтээр ЗХЖШ-ын даргын тушаалын дагуу Зэвсэгт хүчний ахлагчийн эгнээнд элсэж, төрөлх ангидаа ажиллахаар болов.

Дэслэгч Б.ПҮРЭВЛХАМ



ТОРГОН ЦЭРГҮҮД ШИЛДЭГ ГЭДГЭЭ БАТАЛЛАА

Зэвсэгт хүчний 032 дугаар анги

Хугацаат цэргийн алба хаагчдын дунд нөхөрсөг харилцааг бүрдүүлэх, бие бялдрын бэлтгэлжилтийг дээшлүүлэх, багаар ажиллах чадвар, хурд хүч, авхаалж самбааг сорих зорилгоор Зэвсэгт хүчний 032 дугаар ангийн "Ахлагчийн зөвлөл"-өөс 2021 онд хугацаат цэргийн албанд татагдан ирээд бэлтгэлээр халагдаж байгаа дайчдын дунд "Шилдэг дайчин" тэмцээнийг зохион байгууллаа.

Тэмцээн багийн болон ганцаарчилсан төрлөөр болж, урт буу, гар буугаар буудах, автомат задалж угсрах, магазин сумлах, 24 кг-ын туухай өргөх, дүүжинд суниах, тэмээн шатыг туулах, эмнэлгийн татан гаргалт зэрэг найман цэгт даалгавар гүйцэтгэлээ. Багийн төрөлд



долоон баг, ганцаарчилсан төрөлд 16 хугацаат цэргийн алба хаагч оролцсон юм.

Эл тэмцээний нэгдсэн дүнгээр багийн төрөлд тэргүүн байрыг дэд түрүүч Б.Мөнгөнцоож ахлагчтай Хүндэт харуулын тусгай ротын гравдугаар салааны баг тамирчид эзэллээ. Харин ганцаарчилсан төрөлд Хүндэт харуулын тусгай ротын

байлдагч О.Мөнхбат тэргүүн байр, Харуул үйлчилгээний тусгай ротын дэд түрүүч Б.Шижирболд дэд байр, Хүндэт харуулын тусгай ротын дэд түрүүч А.Угтахбаяр гутгаар байрт шалгарч, бусдыгаа манлайлав. Шалгарсан хугацаат цэргийн алба хаагчдыг өргөмжлөл, "Шилдэг тамирчин" тэмдгээр шагнаж урамшууллаа.

БАЯНХОНГОР АЙМАГТ АЛБА ХААСАН ДАЙЧИД НУТАГ НУТГАА ЗОРИЛОО

Зэвсэгт хүчний 339 дүгээр анги

Баянхонгор аймгаас 2021 оны хоёрдугаар ээлжээр цэргийн албанд татагдаж, албаа нэр төртэй хаасан хугацаат цэргийн алба хаагчдаа тус ангийн бие бүрэлдэхүүн болон аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабынхан хүндэтгэн үдлээ.

Энэхүү арга хэмжээнд аймгийн ИТХ-ын дарга Э.Энхбат, ЗДТГ-ын Цэргийн штабын дарга хурандаа Г.Нэмэхбаяр, сумдын ЗДТГ-ын дарга нар болон залуусын ар гэрийнхэн оролцож тэднийг халуун дотноор угтаж, баяр дээр нь баяр нэмсэн юм. Эр цэргийн албаа амжилттай хаасан залуустаа хандан аймгийн ИТХ-ын



дарга Э.Энхбат баяр хүргэж, цаашдын зорьсон үйл хэрэгт нь өндөр амжилт хүсэв.

Б.ПАГАМДУЛАМ

БАРИЛГАЧИН ДАЙЧИД ХАЛАГДАВ



Зэвсэгт хүчний 110 дугаар анги

Цэргийн гавьяаны одонт Зэвсэгт хүчний 110 дугаар ангид хугацаат цэргийн албаа хаасан барилгачин дайчид алба хаах хугацаандаа улс эх орныхоо бүтээн байгуулалтад манлайлан оролцож, Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр замын дээд, доод бүтэц, бетон узель, гүүр хоолойн

ажил, Улаанбаатар-Дархан чиглэлийн хатуу хучилттай авто замын ажил болон намрын ургац хураалтад тус тус томилогдон албан үүргээ нэр төртэй биелүүлсэн билээ. Энэ хугацаанд хугацаат цэргийн 38 алба хаагч цэргийн хэргийн мэдлэгээ дээшлүүлсний зэрэгцээ Орхон аймгийн Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвд барилгын цахилгаанчин, мужаан, сантехникч мэргэжлээр суралцан чадамжийн гэрчилгээтэй төгссөн юм.

Хугацаат цэргийн алба хаагчдыг үдэх ёслолын үеэр албаа үлгэр жишээ хаасан байлдагчдад "Онц сурлагатан", "Онц буудагч" тэмдэг, ангийн 50 жилийн ойн медаль, гэрэл зургийн монтаж, ар гэрт нь талархлын захидал, ангийн байлдааны дэлгээ тугийн зургийг гардуулсан бөгөөд соёл хүмүүжлийн ажлын төлөвлөгөөний дагуу зохион байгуулсан тэмцээн уралдааны шагналуудыг ч гардуулсан юм. Хугацаат цэргийн алба хаагчдаас дөрвөн байлдагч ЗХЖШ-ын даргын тушаалаар дэд ахлагч цол олголоо.

Ахмад Т.МӨНХ-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН БАРУУН ХЯЗГААРТ АЛБА ХААГЧИД НУТГИЙН ЗҮГ ХҮЛГИЙН ЖОЛОО ЗАЛЛАА

Зэвсэгт хүчний 340 дүгээр анги

Тус ангид хугацаат цэргийн албаа нэр төртэй хаасан түрүүч, байлдагчдыг бэлтгэлээр халах, "Байлдааны туг"-нд хүндэтгэл үзүүлэх, үдэн гаргах ёслолын ажиллагааг өнгөрсөн Баасан, Бямба гарагт зохион байгууллаа. Ангийн захирагч хурандаа У.Буянжаргал "Саяхан та нар минь дөнгөж сургуулиа төгссөн хүүхдүүд аймаг, аймгаас цугларан энэ жагсаалын талбай дээр уулзаж байсан бол одоо харахад цэргийн алба, биеэ авч явах чадварт суралцсан, нөхөрлөлийн үнэ цэнийг ойлгосон, зөв төлөвшилтэй амьдралд хөл тавихад бэлэн залуучууд болсон байна. Монгол орныхоо баруун хязгаарт албаа нэр төртэй хаагаад халагдаж байгаа та нараараа бахархаж байна" хэмээх чин сэтгэлийн үгээрээ халагдах дайчдаа урамшуулан үдсэн юм.

2021 оны II ээлжээр хугацаат цэргийн албанд татагдан ирсэн байлдагч Б.Алтан-Уяа, З.Мөнгөншатар нар нь цэргийн албаа үлгэр жишээ хааж, Монгол Улсын томоохон бүтээн байгуулалт болох Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр замын ажилд гар бие,



сэтгэл зүрхээ зориулан оролцож, бусдыгаа манлайлан ахлагчийн албанд элсэж, ЗХЖШ-ын даргын тушаалаар дэд ахлагч цолоор мөрдэс гоёлоо. Мөн цэргийн сургалт бэлтгэл, сурлага, сахилгаараа бусдыгаа манлайлсан дэд түрүүч Л.Чулуунбаатарт түрүүч, ахлах байлдагч О.Ганбаяр, Ц.Азбаяр нарт дэд түрүүч, Б.Түмэнбаярт ахлах байлдагч цол олгосны зэрэгцээ бусад түрүүч, байлдагчдад "Онц буудагч", "Онц сурлагатан" тэмдэг, ар гэрт нь талархлын захидал, ангийн байлдааны дэлгээ тугийн дэргэд авхуулсан гэрэл зургийг дурсгал болгон гардуулан өглөө. Хугацаат цэргийн алба хаагчдад зориулсан "Халагдах цэргийн үдэшлэг"-ийг үлээвэр найрал хөгжимчдийн бүрэлдэхүүн зохион байгуулж, гал тогооныхон амтлаг чанартай, сонголттой хоолоор үйлчиллээ.

Д.УЯНГАА